

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН  
2020 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД  
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОНХС-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХИЙГДСЭН ЗАРИМ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛААГҮЙГЭЭС  
ХӨРӨНГИЙН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

**АУДИТЫН КОД: БНА-2021/58-ШТА-ГА**

Баянхонгор 2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**  
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Аудитын менежер: **А.Цээням**  
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn  
Ахлах аудитор: **М.Алтантуяа**  
Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитор: **Б.Нарангэрэл**  
Утас: 99049866 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

<p><b>Тайланг хянасан:</b>  <b>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар</b></p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор</b>  <b>Б.Мөнхбат</b></p> <p><b>Аудитын менежер</b>  <b>А.Цээням</b></p> <p><b>Тайланг бэлтгэсэн:</b>  <b>Ахлах аудитор</b>  <b>М.Алтантуяа</b>  <b>Аудитор</b>  <b>Б.Нарангэрэл</b></p> <p><b>2021 оны 06 дугаар сарын 22</b></p> <p><b>Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></b></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584 дугаарын утсаар харилцана уу.</i></p> <p><b>ХАЯГ:</b>                  Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар                  Аймгийн ЗДТГ-ын байр,                  Баянхонгор сум,                  Баянхонгор аймаг-64000                  Монгол Улс</p>	<p><b>АГУУЛГА</b></p> <p>ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээ орон нутагт үр дүнгээ өгч байгаа боловч зарим хөрөнгө оруулалт зориулалтын дагуу ашиглахгүйгээс сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна <b>0</b></p> <p><b>АУДИТЫН ДҮН</b> <b>4</b></p> <p>ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээ орон нутагт үр дүнгээ өгч байгаа боловч зарим хөрөнгө оруулалт зориулалтын дагуу ашиглахгүйгээс сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна <b>4</b></p> <p><b>Бүлэг 1. ОНХС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 488.9 сая төгрөгөөр дутуу олгосон, аймаг сумдын ОНХС-д орох хандив, тусламжийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 789.3 сая төгрөгөөр орлого тасарснаас төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна</b> <b>4</b></p> <p><b>1.1</b> Баянхонгор аймагт ОНХС-аас 6,425.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс ОНХС-аас 5,936.9 сая төгрөг, хандив тусламжийн орлого 1,611.5 сая төгрөг төлөвлөснөөс 822.2 сая, өмнөх оны үлдэгдэл болон бусад эх үүсвэрээс 1,330.6 сая төгрөг орохоос төлөвлөснөөс 559.5 сая төгрөг орж нийт эх үүсвэр 1,271.7 сая төгрөгөөр тасарсан байна <b>4</b></p> <p><b>Бүлэг 2. ОНХС-аас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ орон нутагт бодит дэмжлэг болж байгаа боловч ажлын комисс хүлээн авсан байхад хөрөнгө оруулалтын үр нөлөө бүрэн гараагүй, гүйцэтгэгч компани гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг гүйцэтгээгүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна</b> <b>6</b></p> <p><b>2.1</b> Хүрээмарал сумын ОНХС нь "Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт"-ын ажлын дутуу санхүүжилт 6.0 сая төгрөгийг сумын ИТХ-ын тогтоолоор батлуулаагүй, Баянхонгор сумын ИТХ нь 9.9 сая төгрөгийн тоглоомын талбайн ажлын зураг төсөв хийгдээгүй байхад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 болон 60.3.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна <b>6</b></p> <p><b>2.2.</b> Баянхонгор аймгийн "Спорт хорооны их засвар"-ын ажлын санхүүжилтийг аймгийн ИТХ-аас баталсан дүнгээс хэтрүүлэн олгожээ <b>7</b></p> <p><b>Бүлэг 3. Санхүү хяналт, дотоод аудитын алба "ОНХС-ийн 2018-2019 оны хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилт"-д, аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагаанд тус тус хяналт хийж, аймаг, сумын ОНХС-ийн 2020 оны тайлан, мэдээг ХОХБТХ журмын дагуу нэгтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байна</b> <b>11</b></p> <p><b>3.1.</b> ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын алба 2018-2020 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд, аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ОНХС-ийн 2019 үйл ажиллагаанд тус тус хяналтыг хийж тайлагнасан байна <b>11</b></p> <p><b>3.2.</b> Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлагаас 5 албан шаардлага 50 хувийн хэрэгжилттэй ба бусад албан шаардлагаар өгсөн зөрчлийг арилган, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ <b>14</b></p> <p><b>АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> <b>16</b></p> <p><b>АУДИТЫН ЗӨВЛӨМЖ</b> <b>17</b></p>
--	---

	<p style="text-align: center;">Аудитын зорилт, арга зүй, стандартын Талаарх мэдэгдэл</p>
<p>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар “Аудитын төлөвлөгөө батлах тухай” тушаал, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны А/04 дугаар тушаалыг үндэслэн хийлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Дээрх ерөнхий зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх</li> <li>- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх</li> <li>- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх</li> </ul>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг Баянхонгор аймгийн ИТХ, ЗДТГ болон, сумдын ИТХ, ЗДТГ-ыг /цахимаар/ хамруулан шалгав.</p>
<p>Аудитын арга зүй</p>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 400, 4000-4100 дугаар стандартууд, Төрийн аудитын стандарт MNS6817-1, 6, 8: 2020, МУЕА-ын 2020 оны А/106 тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, МУЕА-ын 2021.06.18-ны өдрийн А/71 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал батлах журам”-ыг баримтлан аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт</p>	<p>Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:</p> <p><u>Хуулиуд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн аудитын тухай хууль</li> <li>- Төсвийн тухай хууль;</li> <li>- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт;</li> <li>- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;</li> </ul> <p><u>Засгийн газрын тогтоол:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- МУ-ын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоол;</li> </ul>

<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p> <p>Хүндрэл бэрхшээл</p>	<p><u>Сангийн сайдын тушаал:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;</li> <li>- Сангийн сайдын 2018 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;</li> <li>- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”</li> <li>- Бусад холбогдох хууль, дүрэм, журам;</li> </ul> <p>Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор М.Алтантуяа, аудитор Б.Нарангэрэл, нар хөтөлбөр, хуваарийн дагуу гүйцэтгэв.</p> <p>Аудитын төлөвлөгөөг 2021.05.13-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2021.05.13-ны өдрөөс 2021.06.18-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2021.06.21-ээс холбогдох үе шатны хяналтаар хянуулан Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.</p> <p>Аймаг орон нутагт Ковид цар гарсантай холбогдуулан хөдөө сумдад хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг объект дээр нь үзэх боломжгүй нөхцөл, хүндрэл бэрхшээл үүссэн.</p>
---	---

<p>ААН ЗДТГ ЖДҮ ИТХ ИНХ ОНХНС ОНХС СТСХ ТЕЗ ТЭЗҮ УИХ УТХО ҮАГ ХОХБТХ</p>	<p><u>Товчилсон үгийн тайлбар</u></p> <p>Аж ахуйн нэгж Засаг даргын Тамгын газар Жижиг дунд үйлдвэрлэл Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Иргэдийн нийтийн хурал Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан Орон нутгийн хөгжлийн сан Санхүү, төрийн сангийн хэлтэс Төсвийн ерөнхийлөн захирагч Техник, эдийн засгийн үндэслэл Улсын Их Хурал Улсын төсвийн хөрөнгө оруулалт Үндэсний аудитын газар Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс</p>
--	---

## АУДИТЫН ДҮН

**ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу ашиглаагүйгээс хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна**

**Бүлэг 1. ОНХНС-аас Баянхонгор аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 488.9 сая төгрөгөөр дутуу олгосон, аймаг сумдын ОНХС-д орох хандив, тусламжийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 789.3 сая төгрөгөөр орлого тасарснаас төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна**

1.1 Баянхонгор аймагт ОНХНС-аас 6,425.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс ОНХНС-аас 5,936.9 сая төгрөг, хандив тусламжийн орлого 1,611.5 сая төгрөг төлөвлөснөөс 822.2 сая, өмнөх оны үлдэгдэл болон бусад эх үүсвэрээс 1,330.6 сая төгрөг орохоос төлөвлөснөөс 559.5 сая төгрөг орж нийт эх үүсвэр 1,271.7 сая төгрөгөөр тасарсан байна

1.1.1 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59.3<sup>1</sup> дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тооцон төлөвлөж, Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд улсын төсвөөс Баянхонгор аймагт ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг 7,480.0 сая төгрөгөөр, дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 1,054.2 сая төгрөгөөр бууруулан 6,425.8 сая төгрөгөөр баталсан.

Баянхонгор аймгийн ОНХС-д 3,222.5 сая, 20 сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн 2,564.8 сая, Төсвийн тухай хуулийн 58.2.12<sup>2</sup>-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний зардалд 548.1 сая, 58.2.15<sup>3</sup>-д заасны дагуу хот тохижилт үйлчилгээний зардалд 90.4 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

1.1.2. ОНХНС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59.1<sup>4</sup>-д заасан эх үүсвэрээс дагуу 6,425.8 сая төгрөгийг доорх эх үүсвэрээс оруулахаар тооцсон байна. Үүнд:

- “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс олгох урамшуулал 462.6 сая, дэмжлэг 295.3 сая төгрөг,
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 747.2 сая төгрөг,
- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 743.4 сая төгрөг,
- Суурь зарлага болон итгэлцүүрээр хуваарилагдах дүн 4,177.3 сая төгрөгөөр тооцжээ.

<sup>1</sup> Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

<sup>2</sup> 58.2.12. мал, амьтны халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;

<sup>3</sup> 58.2.15. аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, ийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах;

<sup>4</sup> 59.1.1. импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь;

59.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь; 59.1.3. орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

1.1.3. Аймгийн ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 18 өдрийн хуралдааны 21/03 тоот тогтоолоор аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг батлагдсан аргачлалын дагуу баталсан байна.


Хүснэгт №01 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг /сая.төг/

Сум	Итгэлцүүрээр хуваарилагдсан нийт дүн	ТА-3 төслийн урамшуулал	Дэмжлэг	АМ-ын хайгуулын болон ашиглалтын тусгай	ОНХС-д хуваарилах дүн
Баацагаан сум	54.1	23.6	15.1	22.8	115.6
Баянбулаг сум	34.8	15.2	9.7	7.0	66.7
Баянговь сум	52.0	22.7	14.5	118.9	208.0
Баянлиг сум	82.1	35.8	22.8	47.1	187.7
Баян-Овоо сум	24.3	10.6	6.8	48.7	90.4
Баян-Өндөр сум	85.8	37.4	23.9	53.9	201.0
Баянхонгор сум	150.7	65.7	41.9		258.3
Баянцагаан сум	63.6	27.7	17.7	45.0	154.1
Богд сум	40.4	17.6	11.2		69.2
Бөмбөгөр сум	36.6	15.9	10.2	81.3	143.9
Бууцагаан сум	58.8	25.6	16.4	2.4	103.2
Галуут сум	45.6	19.9	12.7	29.3	107.4
Гурванбулаг сум	42.3	18.4	11.8	7.8	80.4
Жаргалант сум	43.4	18.9	12.1	6.0	80.4
Жинст сум	32.9	14.3	9.1	31.5	87.8
Заг сум	31.6	13.8	8.8	2.1	56.2
Өлзийт сум	31.5	13.7	8.8	15.3	69.3
Хүрээмарал сум	35.2	15.3	9.8	15.4	75.6
Шинэжинст сум	79.6	34.7	22.2	211.0	347.4
Эрдэнэцогт сум	36.3	15.8	10.1	0.0	62.3
Нийт	1,061.6	462.6	295.3	745.3	2,564.8

Эх сурвалж: Сангийн яамнаас ОНХС-аас олгосон хуваарилалт

1.1.4. Баянхонгор аймагт ОНХС-аас 6,425.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс 488.9 сая төгрөгийг дутуу олгосноос сумдад олгох орлогын шилжүүлгийг 61-98 хувийг санхүүжүүлсэн байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн ОНХС-д 98 хувь, Баянхонгор сум, Баянговь, Жинст сумдын ОНХС-д 90-ээс дээш хувь, Галуут сумын ОНХС-д 61 хувь, бусад сумдад 80-87 хувийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт №02 ОНХС-аас аймаг, сумын ОНХС-д олгосон санхүүжилт /хувиар/



Галуут сумын ОНХС нь 2020 онд 10 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 287.4 сая төгрөгийг төлөвлөн эх үүсвэрийг аймгийн ОНХС-аас 107.4 сая, хандив

тусламжийн орлогоос 140.0 сая, урд оны харилцах дансны үлдэгдлээс 40.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр сумын ИТХ-аар баталсан. Гэвч ОНХНС-ийн эх үүсвэр дутуу ирсэнтэй холбоотойгоор аймгаас олгох орлогын шилжүүлгийг 65.8 сая, хандив тусламжийн орлого 53.6 сая төгрөг орж, 127.9 сая төгрөгийн орлого ороогүйгээс 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй явган хүний зам тавих төсөл арга хэмжээ хэрэгжих боломжгүй болжээ.

**Бүлэг 2. ОНХС-аас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ орон нутагт бодит дэмжлэг болж байгаа боловч ажлын комисс хүлээн авсан байхад хөрөнгө оруулалтын үр нөлөө бүрэн гараагүй, гүйцэтгэгч компани гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг гүйцэтгээгүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна**

2.1 Хүрээмарал сумын ОНХС нь "Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт"-ын ажлын дутуу санхүүжилт 6.0 сая төгрөгийг сумын ИТХ-ын тогтоолоор батлуулаагүй, Баянхонгор сумын ИТХ нь 9.9 сая төгрөгийн тоглоомын талбайн ажлын зураг төсөв хийгдээгүй байхад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.4 болон 60.3.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна

2.1.1 Сумдын ИТХ-аас 2020 онд нийт 267 төсөл, арга хэмжээг 3,882.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн, ОНХС-аас 2,564.8 сая, хандив тусламжийн орлогоос Баян-Овоо сум 196.5 сая, Галуут сум 140.0 сая, Бөмбөгөр сум 45.0 сая, Баян-Өндөр сум 30.0 сая нийт 411.5 сая, өмнөх оны үлдэгдлээс 768.5 сая, орон нутгийн төсвөөс Баянлиг сум 0.9 сая, Баянбулаг сум 8.0 сая, өвс тэжээл, малжуулахын эргэн төлөлтийн орлогоос 129.2 сая төгрөгийг оруулахаар нийт 3,882.9 сая төгрөг баталжээ.

Тайланд онд аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлэг 2,143.1 сая төгрөг буюу төлөвлөснөөс 421.7 сая төгрөг дутуу санхүүжилт олгосон нь ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг 488.9 сая төгрөг дутуу ирсэнтэй холбоотой байна.

Хандив тусламжийн орлого Баян-Овоо сум 190.3 сая, Бууцагаан сум 20.0 сая, Бөмбөгөр сум 45.0 сая, Өлзийт сум 3.3 сая, өвс тэжээл болон малжуулах эргэн төлөлтөөс 220.1 сая, өмнөх оны авлага Шинэжинст сум 15.7 сая, Баянбулаг сум орон нутгийн төсвөөс 8.0 сая, төлбөрийн актын эргэн төлөлт 1.1 сая төгрөг нийт 503.5 сая төгрөгийн бусад эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Аудитаар сумдын ОНХС-ийн 2020 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар багийн ИНХ-аас авсан саналыг анхан шатны баримтаас үзэх боломжгүй байсан ба сумдаас ирүүлсэн судалгаа болон onhs.mof.gov.mn сайтад оруулсан иргэдийн өгсөн саналыг мэдээллийг эх сурвалж болгон авч үзлээ.

Сумдын ИТХ-аас 2020 онд өмнөх оноос дамжин ирсэн 34 төсөл арга хэмжээг 586.1 сая, шинээр 230 төсөл арга хэмжээг 3,296.8 сая нийт 267 төсөл, арга хэмжээг 3,882.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Хүрээмарал сумын ОНХС өмнөх оны "Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт"-ын ажлын дутуу санхүүжилт 6.0 сая төгрөгийн үлдэгдлийг ИТХ-аар батлаагүйгээр олгож Төсвийн тухай хуулийн 60.3.6 заалтыг,

- Баянхонгор сумын ИТХ-аар зураг төсөөгүй 9.9 сая төгрөгийн өртөг бүхий тоглоомын талбайн ажлыг баталсан байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 29.4 заалтыг тус тус зөрчсөн тул зөрчил арилгах зөвлөмжийг сумын ИТХ-д хүргүүлж байна.

2.1.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь багийн ИНХ-аас авсан санал, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумдаас ирүүлсэн төсөл арга хэмжээний санал, “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумдын хөгжлийн стратеги төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичиг, Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 21/03 тоот тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтыг 4,846.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс эх үүсвэрийг ОНХС-аас 3,222.4 сая, ТЭЗҮ-ээс 109.2 сая, хандив тусламжийн орлогоос 1,200.0 сая, орон нутгийн орлогоос 314.7 сая, аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг 2,564.8 сая төгрөгөөр төлөвлөж баталжээ.

Аймгийн ОНХС 2020 онд Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан нэр төрлийн дагуу нийт 6,815.1 сая төгрөгийн орлогын эх үүсвэрээс бүрдсэн ба хандивын орлого 1,200.0 сая төгрөг төлөвлөснөөс 636.4 сая төгрөгөөр, өмнөх оны ТЭЗҮ-ээс 109.2 сая төгрөгөөр тасарсан байна.

## 2.2. Баянхонгор аймгийн “Спорт хорооны их засвар”-ын ажлын санхүүжилтийг аймгийн ИТХ-аас баталсан дүнгээс хэтрүүлэн олгожээ

2.2.1. Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг баримталж, тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,714.5 сая төгрөгийн 269 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1<sup>5</sup>-д дагуу сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулалтаар 26 төсөл, арга хэмжээнд 4,704.9 сая төгрөг, харьцуулалтын аргаар 52 төсөл арга хэмжээнд 1,654.0 сая төгрөг, 1,779 төсөл арга хэмжээнд 1,183.6 сая төгрөгийн шууд гэрээ байгуулжээ. Хавсралт судалгаа №2



<sup>5</sup> 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгийг сонгож гэрээ байгуулна:

2.2.2. ОНХС-ийн хөрөнгийг гүйцэтгэгч компанид төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгож байгаа ч Баянхонгор аймгийн “Спорт хорооны их засвар”-ын ажлын санхүүжилтийг төсөв хэтрүүлэн 20.0 сая төгрөг илүү олгосон.

Баянхонгор аймаг, сумын ОНХС-аас 2020 онд 6,891.7 сая төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд, Төсвийн тухай хуулийн дагуу мал эмнэлгийн үйл ажиллагаанд 548.1 сая төгрөг, Хот тохижилтын үйл ажиллагааны зардалд 90.4 сая төгрөг нийт 7,530.3 сая төгрөгийг зарцуулж, ОНХС-ийн харилцах данс нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 641.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №03. ОНХС-ийн хөрөнгийн 2020 оны орлого зарлагын судалгаа /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	2019.12.91-ээрх үлдэгдэл	Нийт орлогын дүн	Нийт зарлагын дүн	2020.12.31-ээрх үлдэгдэл
1	Сумдын дүн	852.8	2,646.5	2,862.6	636.7
2	Баянхонгор аймгийн ОНХСан	375.8	4,033.9	4,029.1	4.8
3	Мал эмнэлгийн үйл ажиллагаанд	-	548.1	548.1	
4	Хот тохижилт	-	90.4	90.4	
	<b>Аймгийн нийт дүн</b>	<b>853.2</b>	<b>7,318.6</b>	<b>7,530.3</b>	<b>641.5</b>

#### Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Баянхонгор аймгийн Спорт хорооны их засварын ажлыг 2019 онд “Ханзол” ХХК-тай 295.4 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан өмнөх онд 160.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож тайланд онд аймгийн ИТХ-ын тогтоолоор 135.4 сая төгрөг олгохоор баталсан байхад гүйцэтгэлээр 155.4 сая төгрөг буюу аймгийн ИТХ-аас баталсан дүнгээс 20.0 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 41.2.2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” заалтыг зөрчсөн тул гүйцэтгэгч Ханзол ХХК-иар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.
- Баянхонгор сумын 30-р байрны их засварын ажилд 11.2 сая, Төв цэнгэлдэхийн их засварын ажилд 22.1 сая, Соого сейкео сургуулийн спорт заалтын барилгын зураг төсөвт өөрчлөлт орсноос 52.5 сая, Галуут сумын Баяннуур 4-р багийн төвийн барилгын ажлын хөлс 10.0 сая төгрөгийн нэмэлт гэрээг тус тус байгуулж төсөвт өртгийн нийт 95.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг алдагдуулж орон нутгийн төсөвт хүндрэл учруулж байна. Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29.4 дагуу ТЭЗҮ, батлагдсан зураг төсвийг үндэслэн баталж, зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

2.2.4. ОНХС-гийн санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээ орон нутагт үр дүнгээ өгч байгаа боловч зарим хөрөнгө оруулалт зориулалтын дагуу ашиглахгүйгээс сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Баянхонгор аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2020 онд 318 төсөл арга хэмжээг 8,729.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсанаас 269 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 11,804.9 сая төгрөгийн гэрээ байгуулж төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс 6,266.2 сая төгрөгийн 221 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ба

эдгээрээс 20 төсөл арга хэмжээнд 429.8 сая төгрөгийн санхүүжилтыг дутуу олгосон байна. Харин дутуу хэрэгжсэн 5,615.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 48 төсөл, арга хэмжээнд 2,332.6 сая төгрөгийн санхүүжилтыг шилжүүлсэн бөгөөд 856.3 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, санхүүжилтыг олгоогүй байна. Хавсралт судалгаа 3.

### **Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүн**

Баянхонгор сумын 4 дүгээр баг, Музейн барилгын дулааны шугам холбох 136.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэгч “Зүүн шанд” ХХК 2019-2020 онд гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Дулааны шугам Баянхонгор аймгийн Музейн 2 барилга цахилгаан халаалт болон нам даралтын уурын зуухыг халж төвийн нэгдсэн халаалтад холбогдсоноор Баянхонгор аймгийн өв соёл болох музейн үзмэр гал, усны эрсдэлээс хамгаалагдсан байна.

“Соого сейкео” сургуулийн спорт заалны барилгыг шинээр ашиглалтад оруулснаар 1200 хүүхдийн сурах орчин сайжирч, стандартын шаардлага хангасан спорт заал, ахлах ангийн 1 анги хичээллэх бүрэн бололцоотой болсон.

Баянхонгор аймгийн ОНХС-аас хэрэгжсэн эрчим хүч, цахилгаан шугам сүлжээ, гэрэлтүүлэгтэй холбоотой 3 төсөл арга хэмжээнд 2019-2021 онд нийт 487.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын үр дүнд дараах үр нөлөө гарсан байна. Үүнд:

#### **Шугам сүлжээний ажил.**

- Баянхонгор аймагт шинэ суурьшлын бүс байгуулагдаж байгаатай холбогдуулан “Шинэ суурьшлын бүс”-ийн гадна цахилгаан хангамжийг стандарт норм дүрмийн дагуу ачаалалд нь тохируулж хийж гүйцэтгэснээр тухайн бүс орчмын хэрэглэгчдийг найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчээр хангах боломжтой болсон.
- Баянхонгор аймгийн Бумбатын тариалангийн талбайн цахилгаан хангамжид дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр айл өрхийн цахилгаан хангамж, гүний худгийн цахилгаан хангамжийг бүрэн шийдсэн байна.
- Герман толгойн тариалангийн талбайн цахилгаан хангамжид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **Гэрэлтүүлгийн ажил:**

- Баянхонгор аймгийн 9-р багт шинээр нийт 151 ш гэрэлтүүлэг, хийгдсэн ба үүнээс лед толгой – 129 ш, төмөр шонтой гэрэлтүүлэг 22ш, хийгдсэн ба 150 Вт 131 ш, 100 Вт 20-ш хийгдсэн.
- Баянхонгор аймгийн 5, 6 –р багт нийт 90 ш гэрэлтүүлгийг 0,4 кВ-ын хуучин модон тулгуурт угсарч гүйцэтгэсэн ба бүгд гэрэл 150 Вт-ын чадалтай лед гэрлүүд угсрагдсан. Баянхонгор сумын 10-р багийн шинээр хийгдсэн зам талбайд нийт 31 ш төмөр баганатай 150 Вт-ын лед гэрэлтүүлэг хийгдсэн байна.

**Ухаалаг тоолуур угсралтын ажил:** Баянхонгор-Эрчим Хүч ЦТ ХХК нь сүүлийн 4 жилд ухаалаг тоолуур нэвтрүүлж хэрэглэгчдийг тоолууржуулж ажиллаж байгаагаас 2020 онд аймгийн хөрөнгө оруулалтаар 3. 6-р багт нийт 1250 ш ухаалаг тоолуур суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Ухаалаг тоолуурын системийг эрчим хүчний сүлжээнд нэвтрүүлснээр дараах сайн талуудтай байна.

- Хэрэглэгч өөрийн хэрэглээгээ тогтмол хянах боломжтой.
- Ямар нэгэн зайлшгүй асуудал гарсан үед яаралтай таслалт хийлгэх боломжтой ба алсаас тасалж залгах хугацаа  $T_{тах}=5с$  байна.
- Тоолуурын заалтыг автоматаар татаж бичилт хийгддэг тул заалт буруу харах, буруу бичилт хийх, илүү тоолох асуудал байхгүй байна.
- Хэрэглэгчийн тоолуурын мэдээллийг хянаж зохицуулах ажлыг автоматжуулсан тул ачаалал хэтэрч гал гарах эрсдэлийг бууруулсан байна.

Ковид цар тахалтай холбогдуулсан сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг цахимаар, аймгийн ОНХС, Баянхонгор сумын ОНХС –ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгахад төсөл арга хэмжээг чанаргүй гүйцэтгэсэн, санхүүжилтийг бүрэн авсан боловч төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажлын комисст хүлээлгэн өгөөгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

**Аудитын илрүүлэлт:**

- *Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн нийтийн эзэмшлийн зам талбайд хог хаягдлын савыг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэхээр шалгарсан "Баян эрдэнийн тогтох" ХХК нь нэг бүр нь 0.5 сая төгрөгийн өртөг бүхий нийт 25 ш хогийн сав хийх байсан ч гүйцэтгэлээр 7 ш хогийн савыг хийж, ажлыг дутуу гүйцэтгэсэн.*
- *Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр "Баянхонгор сумын гэр хорооллын өнгө үзэмжийг иргэдийн оролцоотой сайжруулах" төсөл арга хэмжээг "Очир заан" ХХК 60.3 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан 48.6 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч тус ажлын гүйцэтгэл дутуугаас Баянхонгор сумын ажлын комисс ажлын гүйцэтгэл 85 хувьтай тул хүлээн аваагүй байна. /Санхүүжилтийг аймгийн ОНХС-аас гаргасан боловч төсөл арга хэмжээний хяналтыг Баянхонгор сумын ажлын хэсэг хийсэн/*
- *Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Дурсамж принтинг" ХХК–ийн гүйцэтгэсэн "5 автобусны буудал шинээр барих" ажлыг гүйцэтгэсэн байхад тус ажлыг хүлээн авах ажлын хэсэг томилогдсон ч хүлээн авч, акт үйлдээгүй байна.*
- *Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр 6.0 сая төгрөгийн өртөг бүхий Иргэний танхимын засварын ажлыг гүйцэтгэгч "Хийморь Од" ХХК ажлыг комисс хүлээн авч, акт үйлдээгүй.*
- *Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Эрдэнмандал сургуулийн гаднах спорт цогцолбор талбайн тохижилтын ажлыг гүйцэтгэгч "Есөн од констракшн" ХХК нь 2019.06.21-ны өдрийн №03 тоот 79.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 2020.03.19-ны өдөр 47.7 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч ажлын гүйцэтгэл гаргаагүй, хөл бөмбөгийн талбайн хайс, гоолын хаалга хийгдсэн сандал, сараалжин торыг худалдан авсан боловч угсарч суурилуулаагүй байна.*
- *Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй "2.3.7.9 дүгээр багийн гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалт, интернэт орчин бүрдүүлэх, гамшигийн үеийн дохиоллын сирена суулгах" ажлыг "Бат мод" ХХК нь 2019.03.27 өдрийн 7/57 тоот гэрээгээр 271.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд 2019 онд 40.0 сая, 2020 онд 150.0 сая төгрөгийн санхүүжилт авч 2,3,7,9-р багийн төвийн гудамжны гэрэлтүүлэг, камержуулалтийн ажлыг хийж гүйцэтгэсэн боловч сервер өрөөний тохижилт, аваарын сирэн дохионы ажлууд хийгдээгүй, хүлээлгэж өгөөгүй зөрчлүүд арилгах албан шаардлагыг холбогдох эрх бүхий этгээдэд хүргүүлж байна.*

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хүлээлгэж өгсөн байхад тухайн төсөл арга хэмжээ зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа нь сангийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр "Будума" ХХК нь 100.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан Баянговь, Хүрээмарал сумын үүрэн телефоны сүлжээний өргөтгөлийн барилгын ажлыг дуусган хүлээлгэн өгсөн боловч Хүрээмарал суманд Gtobail үүрэн утасны сүлжээ ороход нарны гэрэлтүүлгийн хүчин чадал хагалалттай бус, Баянговь суманд*

*тавигдсан нарны толиноос 2 ширхэг нь хагарч ашиглах боломжгүй болсон зэргээс шалтгаалан үүрэн утасны сүлжээ ороогүй ОНХС-ийн хөрөнгийн үр нөлөө гараагүй байна.*

2.2.5 ОНХС-ийн 2020 оны хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 3,884.5 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхээс 3,874.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.

Өмнөх аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй 1425.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл тайланд тусгах албан шаардлага өгсний үр дүнд ОНХС-ийн хөрөнгөөр 2020 оны төсөл арга хэмжээг 3,884.5 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхээс 3,874.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- *Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 9.9 сая төгрөгийн өртөг бүхий хүүхдийн тоглоомын талбайг Баянхонгор сумын 14-р цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэх тогтоол гарсан ч хөрөнгөд орлогоор бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2" Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" зөрчсөн тул зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.*

**Бүлэг 3. Санхүү хяналт, дотоод аудитын алба “ОНХС-ийн 2018-2019 оны хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилт”-д, аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагаанд тус тус хяналт хийж, аймаг, сумын ОНХС-ийн 2020 оны тайлан, мэдээг ХОХБТХ журмын дагуу нэгтгэж Сангийн яаманд хүргүүлсэн байна**

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын алба 2018-2020 оны ОНХС-ийн үйл ажиллагаанд, аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ОНХС-ийн 2019 үйл ажиллагаанд тус тус хяналтыг хийж тайлагнасан байна

3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад “Тогтвортой амьжиргаа-3” төслийн Баянхонгор аймгийн төлөөлөгч удирдлага арга зүйгээр ханган ажиллажээ.

Тогтвортой амьжиргаа-3” төслийн зорилго нь ОНХС-ийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах болон орон нутгийн засаглалын чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ сайн засаглал, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт буюу гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгосноор сумын ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах хөшүүргийг бий болгоно. “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийдэг “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ”-ээр анхны жил буюу 2016 онд Баянхонгор аймгийн 20 сумын дундаж үнэлгээ 29% байсан бол 2020 онд 69% болж өссөн байна.

ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлэхдээ иргэдийн оролцоо болон ОНХС-ийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу хэрхэн удирдан зохион байгуулсан зэрэг 6 бүлгийн 34 үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд Баянхонгор аймгийн Өлзийт сум улсын хэмжээнд 2 дахь жилдээ эхний арван сумын жагсаалтад багтсан байна.

## Баянхонгор аймгийн 2020 оны сум бүрийн ЖГҮ-ний үр дүн, бүлгээр



Сумын нэр	Олон нийтийн оролцоо	Төлөвлөлт	Ил тод байдал	Гүйцэтгэл	ХШҮ	Өмчийн удирдлага	Сумын Үнэлгээ
Гурванбулаг	99%	92%	76%	100%	98%	96%	92%
Өлзийт	98%	89%	84%	73%	79%	98%	85%
Жаргалант	100%	84%	70%	90%	44%	95%	82%
Заг	100%	97%	65%	62%	70%	89%	82%
Баян-Овоо	91%	84%	78%	66%	88%	76%	79%
Баянхонгор	82%	81%	73%	79%	63%	65%	76%
Галуут	95%	74%	70%	65%	85%	76%	75%
Жинст	93%	74%	65%	37%	77%	84%	70%
Баянцагаан	79%	76%	70%	55%	44%	90%	69%
Эрдэнэцогт	100%	63%	65%	43%	73%	100%	69%
Бөмбөгөр	57%	75%	68%	58%	98%	52%	68%
Баянлиг	96%	79%	49%	45%	87%	54%	68%
Хүрээмарал	86%	74%	70%	38%	59%	89%	68%
Бууцагаан	81%	84%	70%	56%	25%	61%	67%
Баянбулаг	71%	82%	73%	46%	27%	75%	66%
Баацагаан	85%	66%	70%	39%	69%	57%	63%
Богд	50%	75%	43%	48%	21%	48%	54%
Шинэжист	71%	61%	65%	25%	61%	46%	53%
Баянговь	41%	67%	48%	21%	50%	6%	45%
Баян-Өндөр	29%	40%	65%	52%	13%	16%	41%
<b>Сумдын дундаж</b>	<b>80%</b>	<b>76%</b>	<b>67%</b>	<b>55%</b>	<b>61%</b>	<b>69%</b>	

## Төсвийн төлөвлөлт 2020 онд 2021 оны ОНХС-г төлөвлөсөн байдал



Сумд	Ү5	Ү6	Ү7	Ү8	Ү9	Ү10	Ү11	Ү12	Ү13	Ү14	Төлөвлөлт	Ү5
Заг	100%	100%	100%	100%	100%	100%	81%	100%	100%	100%	97%	Сумын Засаг даргын дэргэдэх ажлын хэсгийг (шөвхр) байгуула, бүрэлдэхүүнд холбогдох мэргэжлийн хүмүүсийг оруулсан эсэх
Гурванбулаг	100%	100%	100%	100%	100%	100%	43%	100%	100%	100%	92%	Ажлын хэсэг хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг боловсруулахдаа 1 ба түүнээс дээш удаа хуралдсан эсэх
Өлзийт	100%	100%	100%	89%	100%	100%	71%	50%	100%	100%	89%	Ажлын хэсэг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг эрэмбэлэхдээ журмын дагуу холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан үзсэн эсэх
Баян-Овоо	100%	100%	100%	100%	100%	100%	52%	100%	100%	38%	84%	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт аймаг/сумын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан эсэх
Жаргалант	100%	100%	50%	55%	100%	100%	52%	100%	100%	100%	84%	Ажлын хэсгээс эрэмбэлэн боловсруулсан жагсаалтад тухайн төсвийн жилд шинээр эхлүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнүүд багийн иргэдийн саналаар дэмжигдсэн эсэх
Бууцагаан	0%	100%	100%	100%	100%	100%	71%	57%	100%	100%	84%	Сумын ИТХ хурал сумын төсвийг хуулийн хугацаанд буюу 12-р сарын 20-ны дотор хэлэлцэж баталсан эсэх
Баянбулаг	100%	100%	0%	100%	100%	100%	57%	100%	100%	100%	82%	Сумын төсвийг хэлэлцэж баталсан Сумын ИТХ-ын ирц бүрдсэн байдал
Баянхонгор	100%	100%	100%	100%	0%	100%	17%	100%	100%	100%	81%	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр санал болгосон хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нэг бүрийг Сумын ИТХ-аар хэлэлцсэн эсэх
Баянлиг	100%	100%	100%	65%	0%	100%	62%	55%	100%	100%	79%	Сумын ИТХ ОНХС-ийн төсвийг зохих маягтын дагуу баталсан эсэх
Баянцагаан	100%	100%	100%	100%	100%	100%	70%	18%	100%	30%	76%	ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авалтын аргыг Сумын Засаг даргын баталсан худалдан авах ажлын хэргийн төлөвлөгөөнд зөв тусгасан эсэх
Богд	100%	60%	0%	82%	100%	100%	52%	82%	100%	100%	75%	
Бөмбөгөр	0%	60%	100%	100%	100%	100%	71%	100%	100%	27%	75%	
Жинст	100%	100%	100%	46%	0%	100%	40%	50%	100%	100%	74%	
Хүрээмарал	100%	60%	100%	91%	100%	100%	85%	0%	100%	40%	74%	
Галуут	0%	0%	100%	100%	0%	100%	68%	100%	100%	100%	74%	
Баянговь	100%	100%	100%	0%	100%	100%	90%	56%	0%	50%	67%	
Баацагаан	100%	60%	0%	91%	0%	100%	62%	50%	100%	100%	66%	
Эрдэнэцогт	100%	100%	0%	100%	0%	100%	42%	92%	100%	36%	63%	
Шинэжист	100%	0%	0%	0%	0%	100%	62%	100%	100%	100%	61%	
Баян-Өндөр	0%	0%	0%	0%	0%	100%	52%	100%	100%	13%	40%	

3.1.2. Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/142 дугаар захирамжаар баталсан “Хяналт -шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11 дүгээр хавсралтаар “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх үзүүлэлтүүд”-ийг журамлан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгажээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны “Сумдын ОНХС-гийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх тухай” хяналт шалгалтын удирдамжаар гүйцэтгэсэн аудитаар сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлд явцын хяналтыг сумын ЗДТГ, иргэд, олон нийтийн оролцоотойгоор Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлан хяналтыг хэрэгжүүлж төсөл, арга хэмжээг хүлээн авсан байгаа боловч захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн талаарх тайлан мэдээ байхгүй байгаад журмын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай гүйцэтгэж

тайлагнаж байхыг зөвлөмжөөр хүргүүлсэн байна. Мөн тус алба нь 2020 онд “ОНХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж аудитын тайлан, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлын тогтоолоор баталгаажуулсан байна.

Өмнөх аудитаар дээрх журмын 9.5<sup>6</sup>, 9.6<sup>7</sup>-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/142 дугаар захирамжаар баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11 дүгээр хавсралтаар 10 заалт бүхий “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх үзүүлэлтүүд” -ийг оруулж гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган баталсан ба тус хэлтсээс Баянхонгор аймгийн ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан байна.

Журмын 10.2<sup>8</sup>-т заасны дагуу Баянхонгор аймаг, сумын tusuv-ogonnutag.mof.gov.mn сайтаар ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд оруулсан байдлыг шалгахад ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд гүйцэтгэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийн мэдээллийг бүрэн оруулсан ба төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн Баянговь сумын ОНХС-ийн мэдээллийг оруулаагүй байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй барилгын их засварууд шинээр баригдаж буй барилгад захиалагчийн хяналтыг Баянхонгор аймгийн ГХБХБГ барилга угсралтын үе шатуудад хяналт тавьж ажиллаж тухай бүр нь заавар, зөвлөгөө өгч ажиллаж байгаа боловч ажил хүлээн авах комисс дутуу хийгдсэн болон чанаргүй хийгдсэн ажлыг хүлээн авсан зөрчил гарсаар байна.

### Аудитын илрүүлэлт

- *Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн Баянхонгор аймгийн Спорт хорооны их засварын ажлыг “Хан зол” ХХК гүйцэтгэн ажлын комисс хүлээн авсан байхад ашиглагч байгууллагаас 2021.06.17 –ний өдрийн 58 тоот албан бичгээр “.. Дээврийн ажил дутуу, бусад засварын ажлын дутуу хийсэн тул гүйцэтгэгч компаниар дахин хийлгэх шаардлагатай” ирүүлсэн нь ажлын комисс хийж дуусаагүй, чанаргүй ажлын хүлээн авсанд гүйцэтгэгч компаниар дутуу ажлыг хийлгүүлэн дахин шалгаж хүлээн авах албан шаардлагыг хүлээн авсан ажлын комисст хүргүүлж байна.*

<sup>6</sup> 9.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ.

<sup>7</sup> 9.6.Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.

<sup>8</sup> 10.2 ОНХС-гийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналт, бүртгэлд удирдлагын мэдээллийн систем ашиглах ба орлогын шилжүүлгийг төлөвлөгөө, батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, санхүүжилты хуваарь, төлбөрийн бүртгэнэ.

3.2. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актыг барагдуулж, албан шаардлагаас 5 албан шаардлага 50 хувийн хэрэгжилттэй ба бусад албан шаардлагаар өгсөн зөрчлийг арилган, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ

3.2.1. Аймаг, сумдын 2020 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг Сангийн яаманд хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2<sup>9</sup>-д заасны дагуу 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сумд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т журамд заасан хугацаанд ирүүлснийг Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь дээрх журмын 9 дүгээр зүйлийн 9.9<sup>10</sup>-д заасны дагуу аймаг, сумдын 2020 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж 2021.3.12-ны өдөр Сангийн яамны ОНХС хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх аудитаар нийт 2,173.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 1.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 1,830.4 сая төгрөгийн зөрчил арилгах 22 албан шаардлагаас 83.0 сая төгрөгийн 5 албан шаардлагаас бусад албан шаардлага, 342.4 сая төгрөгийн 15 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагаас бүрэн хэрэгжүүлээгүй ажлыг дэлгэрэнгүй харуулбал:

д/д	Илрүүлсэн зөрчлийн товч утга	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн биелэлт
Албан шаардлага		
1	Баянхонгор аймгийн ОНХС-гийн 2018 оны хөрөнгөөр Галуут сумын Хайрхан 1-р багт 87.5 сая төгрөгөөр “Нүнжигт инженеринг” ХХК нь багийн төвийн барилга, өвсний агуулахын барилгыг барьж 2018 оны 7-р сард хүлээлгэн өгсөн боловч 2020 оны 9-р сарын 25-ны өдрийн байдлаар өвсний агуулахын төмөр дээвэр хуурч, салбарсан, урд хаалга байхгүй, хажуу талын торон хана нурсан байсныг дахин засварлаагүй байна.	Аймгийн ХОХБТХ-ээс зөрчил арилгах албан бичгийг гүйцэтгэгч компанид хүргүүлсэн боловч “Нүнжигт инженеринг” ХХК нь өвсний агуулахыг засварлаагүй байна.  Биелэлт 0%
2	Баянхонгор аймгийн ОНХС-гаас Бөмбөгөр сумын спорт заал бүхий оффисын барилгын ажлыг 419.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэхээр “Халзан хайрхан” ХХК 2017 оны 12-р сард БХ-2017/А-61 тоот гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж 335.0 сая төгрөг /80 хувь/-ийн санхүүжилт авсан боловч төсөл арга хэмжээг гүйцэтгээгүй байна.	Барилгын төсөвт өртгийг 463.7 сая төгрөг болгон нэмэгдүүлж аймгийн ОНХС-ийн 2020 оны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад орж тайланд онд 74.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгагдсан байхад гүйцэтгэгч компани гүйцэтгэхээс татгалзсанаар 2020 оны аймгийн ИТХ-ын тодотголоор хасагдсан.  Биелэлт 50%

<sup>9</sup> 9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9- д заасан мэдээллийг багтаана.

<sup>10</sup> 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

3	Шинэжинст сумын 33.0 сая төгрөгийн өртөгтэй "HYUNDAI GOLD" маркийн 92-56 БНА улсын дугаартай хог тээврийн автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээг ЗДТГ эзэмшигчээр бүртгээгүй, 50.0 сая төгрөгийн өртөгтэй Gs10-70 маркийн универсал тракторт тээврийн хэрэгслийн гэрчилгээ аваагүй байна.	Шинэжинст сумын 33.0 сая төгрөгийн өртөгтэй "HYUNDAI GOLD" маркийн 92-56 БНА улсын дугаартай хог тээврийн автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээг ЗДТГ-г шилжүүлэн бүртгэсэн. Биелэлт 50%
4	Богд сумын 25.0 сая төгрөгийн өртөгтэй "MITSUBISHI CANTER" маркийн 91-71 БНХ улсын дугаартай хог тээврийн автомашиныг ЗДТГ-ын эзэмшилд шилжүүлж бүртгээгүй байна.	Богд сумын ЗДТГ-аас холбогдох материалыг автомашин зарсан иргэнд хүргүүлсэн боловч Ковид цар тахалтай холбогдуулан баримт бичгийг шилжүүлэх явц удаашралтай байна. Биелэлт 50%
5	Өмнөх оны нийцлийн аудитаар "Баянхонгор-Өлзийт чиглэлийн замын дагуу мод тарих төсөл арга хэмжээнд 112.5 сая төгрөг баталж, 2017 -2018 онд нийт 90.0 сая төгрөг олгосон ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллагаар мод, суулгацыг нэг бүрчлэн тоолж, дүгнэлт гаргуулан үр дүнг тооцох албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Аймгийн ЗДТГ-аас тариалсан модны ургалтыг шалгах ажлын хэсэг байгуулан 2021 оны 7-р сарын 01-ны дотор дүгнэлт гаргахаар ажиллаж байна. Биелэлт 50 хувь

Иймд дээрх хэрэгжилт хангалтгүй байгаа албан шаардлагаар өгсөн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой ажил зохион байгуулж, төрд учирсан хохирлын барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Аудитаар нийт 491.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж 20.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 360.2 сая төгрөгийн зөрчил арилгах хугацаатай 9 албан шаардлага, 111.7 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлэв.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Шууд тайлагнах аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Аймаг сумдын ОНХС-д орох хандив, тусламжийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 789.3 сая төгрөгөөр тасарснаас төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

2. Баянхонгор сумын 30-р байрны их засварын ажилд 11.2 сая төгрөг, Төв цэнгэлдэхийн их засварын ажилд 22.1 сая. Соого сейкео сургуулийн спорт заалтын барилгын зураг төсөвт өөрчлөлт орсноос 52.5 сая, Галуут сумын Баяннуур 4-р багийн төвийн барилгын ажлын хөлс 10.0 сая төгрөгийн нэмэлт гэрээг тус тус байгуулж төсөвт өртгийн нийт 95.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг алдагдуулж орон нутгийн төсөвт хүндрэл учруулж байна.

3. Хүрээмарал сумын ОНХС өмнөх оны "Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт"-ажлын дутуу санхүүжилт 6.0 сая төгрөгийн үлдэгдлийг ИТХ-аар батлаагүйгээр олгосон, Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 9.9 сая төгрөгийн өртөг бүхий тоглоомын талбайн ажлыг зураг төсөвгүйгээр баталж хэрэгжүүлсэн байна.

4. Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг баримталж, тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,714.5 сая төгрөгийн 269 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулсан.

5. ОНХС-гийн санхүүжилтээр хийгдсэн төсөл арга хэмжээ орон нутагт үр дүнгээ өгсөн ч зарим хөрөнгө оруулалт зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаагаас сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

6. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь журмын 9 дүгээр зүйлийн 9.9<sup>11</sup>-д заасны дагуу аймаг, сумдын 2020 оны ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж журамд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн байна.

7. Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлуудаас аудитын үр өгөөж гарч байгаа боловч албан шаардлагаар өгсөн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байсаар байна.

---oOo---

<sup>11</sup> 9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2021.06.23

Баянхонгор хот

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн шууд тайлагнах аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

**Нэг.** Аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танаа

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хандив тусламжийн орлого сүүлийн 3 жил биелээгүйгээс төлөвлөгдсөн ажлууд хэрэгжих боломжгүй болж байгаа тул орлогыг бодитоор төлөвлөж байх.

2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний ТЭЗҮ-ийг магадлалаар баталгаажуулаагүй, мөн зураг төсөвт тусгагдаагүй ажлыг нэмэлт гэрээ байгуулан хийж, төсөвт хүндрэл учруулж байгааг зогсоох.

3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагаар өгсөн төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа тул гэрээ байгуулсан гүйцэтгэгч этгээдийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

4. Баянхонгор аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2017 оноос эхлэн баригдаж байгаа “Бөмбөгөр сумын спорт заал бүхий оффис”-ын барилгад мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан, барилгын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авч ажиллах.

**Хоёр.** Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа танаа

5. Сумын ИТХ-аар батлаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлдэг байдлыг зогсоож, цаашид ОНХС-гийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 60.3.1 заалтад нийцэхгүй төсөл арга хэмжээг ИТХ-р баталж, зарцуулахгүй байхад анхаарч ажиллах.

---оОо---